



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/85/СТА-ТШЗ

Баянхонгор хот 2019 он



Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576 Цахим хаяг: munkhbat.B@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 70442424, 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Ахлах аудитор: А.Цээням

Утас: 99442140, 88011833 Цахим хаяг: tseenyam.A@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийсэн үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.1.1	Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.8.2	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	10
	байхгүй.....	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	12
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.02.23 № 2/43

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ЦЭДЭНДОРЖ ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил

2019 on gerchilgee_Bayanlig sumiin surguuli .docx

2515063

гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн захирал С.Цэдэндорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийсэн үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.14-нөөс 2019.02.19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор А.Цээням хариуцаж хэрэгжүүлэв.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.11-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсролыг сурагчдад эзэмшүүлэн, суралцагчдын

хөгжлийн төлөө багш, эцэг эх хамтран ажиллах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тайлант хугацаанд Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 2.1-т заасны дагуу ерөнхий боловсролын суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд сургалтын үйл ажиллагаагаа чиглүүлж, сургалт хүмүүжлийн ажлыг төлөвлөх, бэлтгэх, зохион байгуулах, үнэлэх ажлыг хамтын оролцоотой хэрэгжүүлэх 11 зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн тооцоолох программ” хангамж ашиглаж гүйцэтгэсэн байна.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2045595,2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 20455,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн мэдээллийг В30102 маягтаар нэгтгэж, баримтжуулсан.

2.1.1 Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал

- Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 3337.9 мянган төгрөгийг хоорондын тооцоогоор буцаан олгохоор тооцсныг нягтлан бодогч тайланд авлагаар тусгаагүй. Мөн үйлдвэрчний эвлэлийн 562,3 мянган төгрөгийн өглөг, НДШ-ийн өглөгийг 117,9 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан зөрчил завсрын аудитаар илэрсэн.

- Аж ахуйн материалын дансанд бүртгэлтэй 30.0 мянган төгрөгийн үнэ бүхий 390 ш 11700.0 мянган төгрөгийн шатрыг сурагчдад олгоод зарлага болгосон, төслөөр ирсэн 2350.0 мянган төгрөгийн 5 ханатай гэрийг аж ахуйн материалд орлого авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 "НББ-д бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага".14.4.3 " бүх өр төлбөрийн заавал тусгана" гэсэн заалтуудыг зөрчсөн, мөн Үнэн зөв байх батламж мэдэгдэл хангаагүй байна.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.2. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлыг санхүүгийн тайланд залруулсан, зөвлөмж өгөгдөөгүй цаашид цалингийн программ ашиглан тооцооллыг гүйцэтгэж, санхүүгийн мэдээллийг программд үнэн зөв тусгаж байхад анхаарч ажиллахыг зөвлөв.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ БАЙХГҮЙ

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд тусгай зориулалтын шилжүүлгээр 969810,2 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдаж бүрэн авсан, мөн дээд шатны төсөв захирагчаас 1287,4 мянган төгрөгийн санхүүжилт авсан, оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 789,4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 10077,2 мянган төгрөгийн санхүүжилт ирснийг зарцуулж үлдэгдэл 3338.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Мөн өөрийн орлогоор үндсэн дансанд 500,0 мянга, нэмэлт санхүүжилийн дансанд 500,0 мянган төгрөг тус тус орсон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”, санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 24 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Мөн хуулийн 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий 18 гүйлгээ мэдээлэхээс 10-р сард 3 гүйлгээний 120,2 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хоцроож мэдээлсэн байна. Цаашид мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж байхыг нягтлан бодогчид, хяналт тавьж ажиллахыг захиралд зөвлөв.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн данснаас шууд зардлаар бүртгэхгүй байх, туслах аж ахуйн орлогыг дансанд төвлөрүүлж, малчны цалинг төсвөөс гаргахгүй байх гэсэн 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

төгрөг

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>58,632,142.13</u>	<u>77,894,165.90</u>
33	АВЛАГА	00.00	3,337,999.98
335	Бусад авлага	00.00	3,337,999.98
3351	Байгууллагаас авах авлага	00.00	3,337,999.98
35	БАРАА МАТЕРИАЛ	58,632,142.13	74,556,165.92
351	Түүхий эд материал	4,344,356.54	4,344,356.54
35110	Тусгай зориулалттай материал	4,344,356.54	4,344,356.54
354	Хангамжийн материал	49,637,785.59	65,561,809.38
35410	Бичиг хэргийн материал	779,098.00	349,110.00
35420	Аж ахуйн материал	48,858,687.58	65,212,699.38
35440	Түлш, шатах тослох материал	00.01	00.00
35600	Мал амьтад	4,650,000.00	4,650,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,510,537,373.83</u>	<u>5,169,100,790.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,510,537,373.83	5,169,100,790.54
392	Биет хөрөнгө	5,510,537,373.83	5,128,970,790.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,558,699,771.00	4,954,145,331.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	-273,054,892.44	-72,663,992.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,500,000.00	15,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-7,750,000.08	-7,965,277.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	246,516,704.14	260,653,664.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	-143,334,635.25	-145,952,677.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	167,241,315.20	177,899,615.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-74,210,754.74	-75,156,924.84
39217	Ном	20,929,866.00	22,511,053.00
393	Биет бус хөрөнгө	00.00	40,130,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	40,130,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,569,169,515.96</u>	<u>5,246,994,956.44</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,569,169,515.96</u>	<u>5,246,994,956.44</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,569,169,515.96	5,246,994,956.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	474,698,217.20	514,828,217.20
51101	Өмч: - төрийн	474,698,217.20	514,828,217.20
512	Хуримтлагдсан үр дүн	5,094,471,298.76	4,081,211,275.55
51210	Өмнөх үеийн үр дүн	5,094,471,298.76	5,094,471,298.76
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,013,260,023.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	650,955,463.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,569,169,515.96</u>	<u>5,246,994,956.44</u>

3.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

СТ-2А

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,087,495,122.00	1,032,335,159.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,902,936.00	27,781,647.00
120	Нийтлэг татварын бус орлого	115,902,936.00	27,781,647.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,902,936.00	27,781,647.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,295,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	115,402,936.00	25,986,447.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	22,778,486.00	34,743,312.68
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	948,813,700.00	969,810,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,190,600.00	10,577,203.68
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,190,600.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	10,577,203.68
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15,587,886.00	24,166,109.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	15,587,886.00	24,166,109.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,094,080,256.48	1,153,821,077.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,094,080,256.48	1,153,821,077.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	998,080,138.48	1,059,886,729.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	553,960,597.00	581,933,473.00
210101	Үндсэн цалин	530,590,433.00	581,933,473.00
210102	Нэмэгдэл	12,419,489.00	00.00
210104	Урамшуулал	10,950,675.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,346,141.00	70,326,602.00
210201	Тэтгэврийн даатгал	75,346,141.00	70,326,602.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,299,325.00	155,695,000.01
210301	Гэрэл, цахилгаан	6,619,325.00	5,681,483.00
210302	Түлш, халаалт	126,680,000.00	150,013,517.01
2104	Хангамж, бараа материалын зардал	4,682,280.00	18,895,016.20
210401	Бичиг хэрэг	3,534,180.00	9,727,388.00
210402	Тээвэр, шатахуун	211,000.00	2,969,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	815,900.00	00.00
210404	Ном, хэвлэл	90,000.00	30,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,200.00	952,620.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	5,215,988.20
2105	Нормативт зардал	15,747,495.00	61,195,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	381,300.00	277,600.00

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	14,558,655.00	58,515,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	807,540.00	2,401,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,582,400.00	2,867,800.00
210604	Урсгал засвар	2,582,400.00	2,867,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,058,000.00	550,500.00
210702	Дотоод албан томилолт	1,058,000.00	550,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	394,000.00	-1,430,399.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	394,000.00	-1,430,399.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	211,009,900.48	169,853,388.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,051,195.13	229,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	2,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,558,705.35	167,124,388.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,000,118.00	93,934,347.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	95,979,086.00	89,806,909.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	15,587,886.00	24,166,109.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,143,800.00	31,878,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	16,887,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	47,559,700.00	16,224,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	687,700.00	650,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,032.00	3,337,999.98
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,032.00	3,337,999.98
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	789,438.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	789,438.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-6,585,134.48	-121,485,917.42
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	891,774,105.79
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	891,774,105.79
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-891,774,105.79
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-6,585,134.48	-1,013,260,023.21

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	972,092,186.00	1,006,348,712.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	500,000.00	1,795,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	500,000.00	1,795,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	500,000.00	1,795,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,295,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	971,592,186.00	1,004,553,512.68

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	948,813,700.00	969,810,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,190,600.00	10,577,203.68
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,190,600.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	10,577,203.68
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	15,587,886.00	24,166,109.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	15,587,886.00	24,166,109.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	972,092,186.00	1,006,348,712.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	972,092,186.00	1,006,348,712.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	856,292,068.00	912,414,365.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	550,799,700.00	581,933,473.00
210101	Үндсэн цалин	442,646,500.00	482,823,973.00
210102	Нэмэгдэл	73,296,400.00	72,966,900.00
210104	Урамшуулал	34,856,800.00	26,142,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,707,038.00	70,326,602.00
210201	Тэтгэврийн даатгал	58,707,038.00	54,352,502.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	4,737,142.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	3,897,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	974,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	6,364,758.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,522,045.00	155,695,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,842,045.00	5,681,483.00
210302	Түлш, халаалт	126,680,000.00	150,013,517.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,941,480.00	7,346,120.00
210401	Бичиг хэрэг	3,482,160.00	1,890,280.00
210402	Тээвэр, шатахуун	4,969,920.00	3,198,820.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	815,900.00	00.00
210404	Ном, хэвлэл	1,089,000.00	642,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,584,500.00	1,615,020.00
2105	Нормативт зардал	66,594,865.00	60,032,950.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	531,300.00	277,600.00
210502	Хоол, хүнс	58,390,165.00	58,515,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,673,400.00	1,239,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,582,400.00	2,867,800.00
210604	Урсгал засвар	2,582,400.00	2,867,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,058,000.00	550,500.00
210702	Дотоод албан томилолт	1,058,000.00	550,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,152,100.00	2,460,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,152,100.00	2,460,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,934,440.00	31,201,020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,134,440.00	7,131,020.00

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,800,000.00	24,070,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,800,118.00	93,934,347.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,779,086.00	89,806,909.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	15,587,886.00	24,166,109.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,143,800.00	31,878,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	16,887,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	47,559,700.00	16,224,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,487,700.00	650,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,032.00	3,337,999.98
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,032.00	3,337,999.98
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	789,438.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	789,438.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТ-4А

төгрөг

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,698,217.20	00.00	5,094,471,298.76	5,569,169,515.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	474,698,217.20	00.00	5,094,471,298.76	5,569,169,515.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	650,955,463.69	00.00	650,955,463.69
D08	Тайлант үеийн үр дүн			-1,013,260,023.00	-1,013,260,023.00
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	514,828,217.20	650,955,463.69	4,081,211,275.55	5,246,994,956.44

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

төгрөг

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	932,864,800.00	932,564,800.00	970,310,200.00	970,808,161.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	932,864,800.00	932,564,800.00	970,310,200.00	970,808,161.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	831,918,400.00	831,618,400.00	904,661,600.00	905,167,361.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548,280,500.00	548,280,500.00	581,859,600.00	576,654,869.30
210101	Үндсэн цалин	441,794,500.00	441,794,500.00	476,137,600.00	477,545,369.30
210102	Нэмэгдэл	61,172,300.00	61,172,300.00	72,671,800.00	72,966,900.00
210104	Урамшуулал	45,313,700.00	45,313,700.00	33,050,200.00	26,142,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,421,700.00	60,421,700.00	64,536,600.00	70,326,602.00
210201	Тэтгэврийн даатгал	60,421,700.00	60,421,700.00	64,536,600.00	54,352,502.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	00.00	4,737,142.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	00.00	3,897,500.00
210204	Ажилгүйдлийндаатгал	00.00	00.00	00.00	974,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	00.00	6,364,758.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	126,657,200.00	126,422,203.00	155,694,000.00	155,695,000.00
210301	Гэрэл, цахилгаан	7,097,200.00	6,302,721.00	8,196,200.00	5,681,483.00
210302	Түлш, халаалт	116,360,000.00	119,627,448.00	146,717,800.00	150,013,517.00
210303	Цэвэр, бохир ус	3,200,000.00	492,034.00	780,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,338,100.00	10,338,100.00	7,341,500.00	7,338,320.00
210401	Бичиг хэрэг	1,312,300.00	2,482,800.00	1,169,500.00	1,882,480.00
210402	Тээвэр, шатахуун	4,008,000.00	4,008,000.00	2,970,000.00	3,198,820.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,556,500.00	1,782,100.00	703,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	493,500.00	433,000.00	883,900.00	642,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,967,800.00	1,632,200.00	1,615,100.00	1,615,020.00
2105	Нормативт зардал	58,664,100.00	58,626,895.00	60,110,000.00	60,032,950.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	539,300.00	539,300.00	413,400.00	277,600.00
210502	Хоол, хүнс	57,185,200.00	57,147,995.00	58,593,000.00	58,515,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	939,600.00	939,600.00	1,103,600.00	1,239,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,019,100.00	4,005,302.00	2,867,800.00	2,867,800.00
210604	Урсгал засвар	4,019,100.00	4,005,302.00	2,867,800.00	2,867,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,013,000.00	999,000.00	550,500.00	550,500.00
210702	Дотоод албан	1,013,000.00	999,000.00	550,500.00	550,500.00

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ТОМИЛОЛТ				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	972,200.00	972,200.00	500,300.00	500,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	972,200.00	972,200.00	500,300.00	500,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21552500.00	21552500.00	31201300.00	31201020.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,552,500.00	21,552,500.00	7,131,300.00	7,131,020.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	24,070,000.00	24,070,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100946400.00	100946400.00	65648600.00	65640800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,946,400.00	100,946,400.00	65,648,600.00	65,640,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,522,200.00	32,522,200.00	31,878,600.00	31,878,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,237,700.00	52,237,700.00	16,887,600.00	16,887,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,186,500.00	16,186,500.00	16,224,600.00	16,224,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	657,800.00	650,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	933,313,700.00	933,064,800.00	970,310,200.00	970,808,161.30
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	932,813,700.00	932,564,800.00	969,810,200.00	969,020,761.30
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	932,813,700.00	932,564,800.00	969,810,200.00	969,020,761.30
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	500,000.00	500,000.00	1,787,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	500,000.00	500,000.00	500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	00.00	1,287,400.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	66	68	67	68
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	51	53	52	53
620003	Үйлчлэх ажилтан	14	14	14	14
63	Суралцагчдын тоо	745	745	745	745

Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	2	3	4	5	6
630	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	745	745	745	745
630001	Төрийн өмчит ЕБС	745	745	745	745
65	Орон тооны мэдээлэл	66	68	67	68
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	48	50	49	50
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18	18	18	18